

ДЭЛХИЙН ЦӨМИЙН ЗЭВСЭГГҮЙ БҮСҮҮД

С.Баясгалан *

Анх 1945 оны 6 дугаар сарын 16-нд АНУ Нью Мехико мужийн Аламогордод цөмийн зэвсэг туршиж, 1945 оны 8 дугаар сард Японы Хирошима, Нагасаки хотуудад цөмийн зэвсэг хэрэглэснээр цөмийн эрин үе (Nuclear Age) эхэлсэн гэж үздэг. Японы Хирошимад хаясан цөмийн бөмбөг хүн төрөлхтөн урьд нь ямар ч дайнд үзэж байгаагүй үр дагавар үзүүлснээрээ дэлхий дахиныг цочролд оруулсан юм.¹ Үүнээс хойш хүн төрөлхтөн цөмийн зэвсэг ямар аюултай болохыг мэдэх болсон. Тухайн үед цөмийн зэвсгийг эзэмшдэг ганц улс нь АНУ байж, уг зэвсэгтээ дулдуйдсан гадаад бодлого явуулах болов. Гэвч “хүйтэн дайн”-ы үед 1949 оны 8 дугаар сарын 29-нд ЗХУ цөмийн зэвсэгтэй болсноор хоёр их гүрний хүч тэнцэж хоёр туйл болон сөргөлдөх болсноор улс орнууд өөрсдийн аюулгүй байдлыг хангах, давамгайл байдлаа хадгалах зорилгоор цөмийн зэвсэглэлээр хөөцөлдөж эхлэн үзэл суртлын хоёр лагерьт хуваагдаж бие биенийхээ эсрэг цөмийн зэвсэг онилох болжээ.

Хоёр их гүрний цөмийн зэвсэгтээ дулдуйдан бие биенээ сөрөн зогссон бодлого нь хүрээгээ тэлж бусад улс орнуудыг хамрах болов. АНУ болон ЗХУ нь “хүйтэн дайн” эхэлснээс хойш НҮБ-аар дамжин харилцаж, бие биенээсээ зэвсгийн хүчээр давуу байдалтай болох гэж улайрч байсан. Үзэл суртлын дайн, зэвсэглэлээр хөөцөлдөх хоёр гүрний өрсөлдөөн улам даамжирсаар 1962 онд Карибын хямралд хүргэв.

1962 онд ЗХУ Кубын арал дээр цөмийн пуужин байрлуулснаар хямрал дээд цэгтээ хүрсэн билээ. Энэхүү үйл явдал 1962 оны 10 сарын 14-нд АНУ-ын тагнуулын онгоц Кубын арал дээгүүр нисэхдээ пуужин байрлуулж байгааг олж илрүүлснээр Карибын хямрал гарсан юм. ЗХУ АНУ-ын хилээс 140 бээрийн зайд орших Кубын арал дээр дунд тусгалын пуужинг суурилуулсан нь АНУ-ыг цочирдоход хүргэв. Учир нь ЗХУ-ын суурилуулсан дунд тусгалын пуужин нь Вашингтон хотод хүрэх хэмжээний тусгалтай байв. ЗХУ Кубын аралд пуужин байрлуулсны хариуд Жон Ф.Кеннеди суурилуулсан байгууламжийг бөмбөгдөх, Кубын арал руу дайрах, хорио тогтоох гэсэн аргуудаас сүүлийнхийг нь сонгож

* МУИС, ОУХС-ийн багш, докторант

¹ Цөмийн дэлбэрэлт нь энгийн бөмбөгийн дэлбэрэлтээс 100, бүр 1000 дахин хүчтэй юм. Эдгээр зэвсгүүд нь дэлбэрэлтийн хүч буюу устгах долгион ялгаруулдаг. Энгийн болон цөмийн зэвсэглэлийн ялгаа нь цөмийн зэвсэг аль ч энгийн зэвсэгт байдаггүй их дулааныг ялгаруулдаг ба энэхүү дулаан нь хурц гэрэл, өндөр халуун ялгаруулдаг, үүнийг нь термал энерги ч гэж нэрлэдэг. Энэ энерги арьс түлэх болон дэлбэрэлт болсон газраас хол байгаа газарт гал тавих үндэстэй. Мөн янз бүрийн төрлийн хорт радиаци ялгаруулдаг. Эдгээр нь хэдхэн секундээс нэлээд удаан хугацаагаар үргэлжлэх боломжтой. Цөмийн зэвсгийн энергийн 85% орчим нь агаарын дэлбэрэлт буюу шок байдаг. Үлдсэн 15% нь цөмийн янз бүрийн радиаци хэлбэрээр гардаг. 5% нь анхдагч цөмийн радиаци ба эдгээр нь голчлон гамма долгион болон нейтроныг байдаг.

Кубын арлыг 183 усан онгоцоор далайн бүслэлт үүсгэж, зэвсэг техник төвлөрүүлж байлдааны бэлэн байдалд оруулсны зэрэгцээ Газрын дундад тэнгис, Тайваний хоолой дахь АНУ-ын 6, 7-р флотыг байлдааны бэлэн байдалд оруулав².

АНУ пуужингаа татаж авах талаар ЗХУ-тай ойлголцохыг хүсэж байсан ба ЗХУ Куба улс руу дайрахгүй байх, Туркт байгаа дунд тусгалын пуужингуудаа авбал өөрийн пуужингуудаа татахаа мэдэгдэв.³ Кубын хямралаас сургамж авсан Карибын болон Латин Америкийн улс орнууд их гүрнүүдийн нөлөөгөө тогтоох гэсэн цөмийн зэвсэг оролцсон ашиг сонирхлын мөргөлдөөнд татагдан орохгүй байх үүднээс тус тусын нутаг дэвсгэрээ цөмийн зэвсгээс ангид байлгах тухай гэрээ байгуулахаар болсон. Карибын хямралаас сургамж авсан их гүрнүүд цөмийн аюулгүй байдлыг хангах талаар хүчин чармайлт гаргах болсны нэг илрэл нь тэдний хооронд байгуулагдсан гэрээ, хэлэлцээрүүд⁴ юм. Олон улс цөмийн зэвсэгтэй болох тусам зэвсэг хэрэглэх, осол гарах, бодлогогүй ашиглах, жижиг хэмжээний цөмийн зэвсэг хэрэглэсэн мөргөлдөөн гарах замаар олон улсын аюулгүй байдлын баталгаа улам алдагдах магадлалтай байсан нь хэт их гүрнүүдийг хэлэлцээний ширээний ард суухад нөлөөлсөн юм.

Ингээд 1968 оны “Цөмийн зэвсэг үл дэлгэрүүлэх тухай” гэрээ байгуулж түүний 7-р зүйлд “Цөмийн зэвсэглэлээр хөөцөлдөх өрсөлдөөнийг таслан зогсоож, үй олноор хөнөөх зэвсгийн тархалтад хяналт тавихад хэсэг бүлэг улсын өөрийн нутаг дэвсгэр дээр цөмийн зэвсгийг бүрэн хориглох зорилготой гэрээ байгуулах эрхийг хөндөхгүй”⁵ гэж заасныг бүс нутгийн улс орнууд цөмийн зэвсэггүй бүс байгуулах явдал нь цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх зорилтыг хэрэгжүүлэх чухал арга зам⁶ гэж үзэхэд нөлөөлсөн байна. Гэрээний энэхүү заалтыг үндэслэн дэлхийн бусад улс орнууд цөмийн зэвсэггүй бүс болохоо зарлаж байв. “Цөмийг үл дэлгэрүүлэх” гэрээ нь цөмийн зэвсгийн тархалтыг хязгаарлах олон улсын гэрээ юм. Энэхүү гэрээг анх Ирланд, Финлянд улсууд санал болгож, 1968 оны 7 дугаар сарын 1-нд гарын үсэг зурсан. Одоогоор 189 орон гэрээнд нэгдэж ороод байгаа ба тэдгээрийн дунд НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн (АЗ) байнгын таван гишүүн болох АНУ, Их Британи, Франц, ОХУ, БНХАУ багтаж байгаа юм. Гэрээнд нэгдэж

² Д.Цолмон “АНУ-ын гадаад бодлогын түүх, дипломат ажиллагаа”, УБ, 2005, 230-р тал

³ “US-Soviet Exchange during Cuban Missile Crisis”, http://en.wikisource.org/wiki/US-Soviet_Exchange_during_Cuban_Missile_Crisis Хрущевын Кеннедид илгээсэн захидалаас

⁴ 1963 Memorandum of Understanding between the US and the USSR Regarding the Establishment of a Direct Communications Link, Annex

US-Soviet Nuclear Accidents Agreement

1971 Agreement on Measures to Reduce The Risk of Outbreak of Nuclear War

US/USSR Incidents at Sea Agreement

1972 Agreement on the Prevention of Incidents on and over the High Seas

US/USSR Nuclear War Prevention

1973 Agreement on the Prevention of Nuclear War

US/USSR Risk Reduction

1987 Agreement on the Establishment of Nuclear Risk Reduction Centers, Protocols

US/USSR Launch Notification

1988 on Notifications of Launches of Intercontinental Ballistic Missiles and Submarine-launched Ballistic Missiles

US/USSR DMA Agreement

1989 Agreement on the Prevention of Dangerous Military Activities, Annexes, Agreed Statements

US/USSR Major Exercises

1989 Agreement on Reciprocal Advance Notification of Major Strategic Exercises

⁵ Үл дэлгэрүүлэх гэрээ 1968 он 7-р зүйл

⁶ Договор о нераспространении ядерного оружия. // “Антология мировой политической мысли” т. V. Политические документы. М. 1997. стр. 533

ороогүй цөмийн зэвсэг бүхий Энэтхэг, Пакистан, Израиль, БНАСАУ гэсэн дөрвөн улс байдаг. Үүнд: Энэтхэг, Пакистан хоёр цөмийн зэвсэг туршсан улсууд. Израиль цөмийн зэвсгийн хөтөлбөрийн талаар тодорхойгүй бодлого явуулдаг. БНАСАУ гэрээнд нэгдэн орсон байсан ч сүүлд гэрээг зөрчин улмаар гэрээнээс гарсан юм.

Цөмийн зэвсэгтэй таван гүрэн гагцхүү тухайн улс цөмийн зэвсэгтэй улсын холбоотон болж энгийн эсвэл цөмийн зэвсгээр дайснаас бусад тохиолдолд цөмийн зэвсэггүй улсуудын эсрэг цөмийн зэвсэг хэрэглэхгүй байх үүрэг хүлээсэн. Хэдийгээр улс орнууд “Үл дэлгэрүүлэх” гэрээнд нэгдэн орсон ч энэ нь цөмийн зэвсгийн тархалтыг хязгаарлаж чадахгүй байсан төдийгүй зарим боломжийн улс орнууд уг гэрээнд нэгдэхээс түтгэлзэж цөмийн хөтөлбөр боловсруулсаар ирсэн. Иймээс дэлхийн улс орнуудад хоёр арга зам байсан. Энэ нь 1-д өөрийн аюулгүй байдлаа цөмийн зэвсэгтэй их гүрнүүдийн батлан хамгаалахын нөмрөг буюу “цөмийн шүхэр”^{*} доор хангах, 2-т бүс нутгийн улс орнууд хоорондоо гэрээ байгуулан Цөмийн зэвсэггүй бүс байгуулах явдал байв.

Ихэнх улс орнууд цөмийн зэвсэггүй бүс байгуулах арга замыг сонгон авсан ба тэдгээр нь “Үл дэлгэрүүлэх” гэрээний заалтыг иш үндэс болгосон байдаг. 1985 оны “Раротонгийн гэрээ” болон бусад цөмийн зэвсэггүй бүс байгуулах тухай гэрээнүүдийн удиртгал хэсэгт Цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх гэрээний 7-р зүйлийг үндэслэн цөмийн зэвсэггүй бүс үүсгэж байгаагаар тодорхойлогдож байдаг ба Латин Америкийн улс орнууд “Тлателолкийн гэрээ”-нд заасан цөмийн зэвсгээс ангид байх тус бүс нутгийн улс орнуудын эрмэлзлийг энэхүү заалт албан ёсоор хангаж байдаг. Гэвч цөмийн зэвсэг нь их гүрнүүдийн стратеги бодлогын нэг хэсэг болсон учраас ямар ч бүс нутагт гадаад бодлого явуулахад цөмийн зэвсгийг хориглох нь их гүрнүүдийн геополитикийн болон геостратегийн ашиг сонирхлыг хөндсөн байдаг тул цөмийн зэвсэг болон цөмөөс ангид байх аливаа гэрээний протоколд цөмийн зэвсэгтэй гүрнүүд нэгдэн орж, соёрхон баталсан байх тухай заалтууд байдаг.

Өнөөдрийг хүртэлх хугацаанд нэг хэсэг улс нь цөмийн зэвсэгтэй болох замаар өөрийн үндэсний аюулгүй байдлыг хангах, олон улсын тавцан дахь сүр хүчээ өсгөхийг эрмэлзэж ирсэн бол нөгөө хэсэг нь түүний аймшигт үр дагавраас болгоомжлон цөмийн зэвсгийг дэлгэрүүлэхгүй байхын төлөө тэмцэж ирсэн. Үүний дүнд цөмийн зэвсгийн тархалтыг зогсоох олон арга хэрэгсэл, механизм, эрх зүйн хэм хэмжээг үүсгэсний нэг нь цөмийн зэвсэггүй бүс юм. Өөрөөр хэлбэл цөмийн зэвсэг эзэмшигч их гүрнүүдийн цөмийн дипломат бодлогыг хязгаарлах бодит арга зам нь “цөмийн зэвсэггүй орон зай”-г Олон улсын цөмийн эрчим хүчний агентлаг (ОУЦЭХА)-ийн нөмрөг доор баталгаажуулан тэлэх явдал гэж үздэг. Үл дэлгэрүүлэх гэрээнд оролцогчид 1995 оны 5 дугаар сард гэрээг тодорхой бус хугацаагаар сунгахдаа “Цөмийн зэвсэг үл дэлгэрүүлэх ба Зэвсэг хураахын зорилго, зарчмууд” гэсэн баримтыг баталж, цөмийн зэвсэггүй бүс байгуулахыг тэргүүн асуудал болохыг дэмжсэн байдаг.⁷

Дэлхийн цөмийн зэвсэггүй бүсүүд

^{*} өнөөгийн байдлаар үүнд НАТО-гийн гишүүн Европын улс орнууд, Япон, Өмнөд Солонгос мөн Австрали, Шинэ Зеланд зэрэг орнууд ордог байна.

⁷ Т.Ариунсанаа. Олон улсын цөмийн зэвсэггүй бүс. 16-р тал

АНУ, ЗХУ-ын сөрөн зогсолт дэлхийн хяналтгүй байгаа орон зайд бие биендээ давамгайл байдлыг буй болгохгүй байхад чиглэж байсан ба эдгээрт Антарктик, сансар огторгуй, усан орон зай орж байв. Аль алиндаа давамгайл байдлыг олгохгүй байлгах үүднээс эдгээр бүс нутгуудыг аливаа цэргийн үйл ажиллагаа болон цөмийн зэвсгээс ангид байлгахад болж 1961 оны 6 сарын 23-нд “Антарктикийн гэрээ”-г байгуулсан юм. Уг гэрээнд тус тивд цэргийн үйл ажиллагаа явуулах, цэргийн зориулалттай аливаа төхөөрөмжийг гагцхүү энхийн, судалгааны зорилгоор ашиглахаар заасан.

Сансар огторгуйн гэрээ 1967 оны 10 сарын 10-нд хүчин төгөлдөр болсон. Одоогийн байдлаар 98 улс нэгдэн орсон байгаа. Энэхүү гэрээнд цөмийн зэвсэг эсвэл үй олноор хөнөөх аливаа зэвсгийг Дэлхийн тойрог зам, сар болон бусад сансрын эрхэст байрлуулахыг хориглож, сар болон сансрын бусад эрхэс гагцхүү энхийн зорилгод ашиглаж, цөмийн болон бусад аливаа зэвсэг турших, цэргийн зориулалтаар ашиглахыг хориглосон байдаг.

1972 оны 5 сарын 18-нд АНУ, Их Британи, ЗХУ болон бусад 22 улс соёрхон баталснаар далайн ёроолд зэвсэглэл хянах гэрээ хүчин төгөлдөр болов.

Тлателолкийн гэрээ буюу Латин Америкийн цөмийн зэвсэггүй бүсүүд

Цөмийн зэвсгээс ангид байх бүсүүдийн* дараа энэхүү бүс нь дөрөв дэх нь болж байгаа бөгөөд хүн ам шигүү суурьшсан тивийг хамарч байгаагаараа онцлогтой. Дээр дурьдсанчлан 1962 оны Карибын хямрал Латин Америкийн улс орнууд “хүйтэн дайн”-ы үед хэрхэн хоёр их гүрнийн цөмийн зэвсгийн өрсөлдөөний талбар болох аюултайг тодоор харуулж өгсөн. Үүний дараа 1963 оны 4-р сард Болив, Бразил, Чили, Эквадор, Мексик зэрэг таван орны төрийн тэргүүн нар Латин Америкт ЦЗБ байгуулах олон талт гэрээ байгуулахад бэлэн байгаагаа мэдэгдэж, НҮБ-ын дэмжлэгийг аван 1967 оны 2-р сарын 14-нд Мехико хотын ойролцоох Тлателолкод хуралдаж гэрээг баталсан ба 1969 оны 4 дүгээр сарын 25-нд хүчин төгөлдөр болж түүнээс хойш Латин Америкийн 33 улс нэгдэн ороод байна. Латин Америкт үүссэн цөмийн зэвсэггүй бүс нь олон улсын хэмжээнд цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх, зэвсэглэлээр хөөцөлдөх явдлын эсрэг авч хэрэгжүүлсэн хэсэг бүлэг улсуудын анхны алхам болохын хувьд онцлог байв.

Тлателолкогийн гэрээгээр цөмийн зэвсэггүй бүсийн статус, цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэхэд тавих тогтмол ажиллагаатай хяналтын систем, механизмыг үүсгэсэн нь бас нэгэн онцлогтой ба бүс нутагтаа нөлөө бүхий буюу цөмийн аливаа үйлдвэрлэлийг явуулах чадвартай улс орнууд нэгдэн орсноороо чухал ач холбогдолтой болов.

Раротонгийн гэрээ буюу Өмнөд Номхон далайн цөмөөс ангид бүс

АНУ 1946 оноос эхлэн Бикини, Эневетак, Христмас арал, Жонсон аралд тус тус цөмийн туршилт хийж байсан. Тухайлбал 1952 оны 11 дүгээр сард Маршалын арлуудын Энэветакт цөмийн туршилт хийсэн. Франц 1966 онд Муруроад цөмийн туршилт хийж эхлэв. Нөгөө талаар Солонгосын дайн дэгдсэн 1950-иад оны үед АНУ-ын агаарын хүчин Хятадын оршин тогтнол, аюулгүй байдалд аюул учруулж байсан төдийгүй чухамдаа энэ үед АНУ Хятадын эсрэг

* Антарктикийн гэрээ, сансрын орон зай, далайн ёроолын тухай гэрээ

цөмийн зэвсэг хэрэглэхээр сүрдүүлж байв. Үүний улмаас 1956 онд Хятадын эрх баригчид цөмийн зэвсэгтэй болох талаар судалгаа хийж эхэлсэн байна.

Дэлхийн хоёрдугаар дайны дараа АНУ, Их Британи болон Франц улсууд Өмнөд номхон далайн алслагдмал зэлүүд аралд удаа дараагийн туршилт ойр ойрхон явуулах болов. 1975 онд Шинэ Зеланд Номхон далайд их гүрнүүдээр цөмийн туршилтыг цаашид явуулахгүй байх үүднээс өөрийн хөрш Өмнөд Номхон далайн орнууд болох Науру, Фижи, Тонго, Күкийн арал, Папуа шинэ Гвиней, Австрали, Баруун Самоа зэрэг арлын орнуудыг хамарсан Өмнөд Номхон далайд цөмөөс ангид бүс байгуулахыг санаачилсан нь дэмжигдсэн. Дээрх орнууд Тувалуд болсон XV чуулга уулзалтаас тус бүс нутгийг цөмийн зэвсэггүй бүс болгохоор санаачлага гаргасан юм. Уг санаачлагын дагуу 1985 оны 7 дугаар сарын 8-нд Номхон далайн өмнөд хэсэгт цөмийн зэвсэггүй бүс үүсгэх тухай Раротонгийн гэрээг 10 улс баталсан бөгөөд 1986 оны 12 дугаар сарын 11-ээс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн байна.

“Раротонгийн гэрээ”-ний гол онцлог нь цөмөөс ангид бүс хэмээх ойлголтыг олон улсын эрх зүйн үүднээс гаргаж ирсэн. “Цөмийн зэвсэг” бус “цөмийн аливаа цацраг ялгаруулах чадвар бүхий бодис” хэмээх ойлголтын хүрээнд авч үзсэнээр цөмөөс ангид байхыг өргөн утгаар авч хэрэглэн цөмийн зэвсгээс гадна цөмийн хог хаягдал байрлуулахгүй байх, цөмийн туршилтыг хориглосон зэрэг олон шинэлэг талуудыг тусгасны зэрэгцээ уг бүс нутаг дэвсгэрт төдийгүй бүсийн хил дагуу цөмийн туршилт хийхийг хориглосон нь уг бүсийн статус, цөмийн зэвсгээс ангид байх чанарыг нь илүү баталгаатай болгосон юм.

Пелиндабагийн гэрээ буюу Африкийн цөмийн зэвсэггүй бүсүүд

Өмнөд Африкийн засгийн газар бүс нутагтаа товойн гарах, мөн апартейд бодлогоо хэрэгжүүлэх зорилгоор үй олноор хөнөөх зэвсэг хийх болсон ба үүн дотор цөмийн зэвсэг багтаж байв. Франц улс Африкийн Сахарт цөмийн туршилт хийснээс 1960 онд Африкт ЦЗБ байгуулах асуудал яригдаж эхэлсэн байна. Жилийн дараа Африкт аливаа цөмийн туршилт хийх, тус тивийг туршилтын талбай, цөмийн зэвсэг хадгалах болон дамжин өнгөрүүлэхээр ашиглуулахгүй байх, НҮБ-ийн Ерөнхий Ассамблей (ЕА)-гаас 1961 оны 11-р сарын 24-нд баталсан Африкийн ЦЗБ-ийн талаар 1652 тогтоолыг хүндэтгэн үзэхийг уриалсан байна.⁸

ӨАБНУ цөмийн туршилт хийсэн нь Өмнөд Африк цөмийн зэвсэгтэй болох гэж байгаа гэсэн болгоомжлолыг төрүүлэх болов. Энэ нь 1977 онд Калахарын цөлд хийсэн газар доорх тэсэлгээ байв. Тухайн үед ЗХУ, Франц, АНУ ӨАБНУ-ын цөмийн хөтөлбөрөөс болгоомжилж байв. 1990-ээд оны эхээр ӨАБНУ дахь апартейд дэглэм унаж, “хүйтэн дайн” төгсгөл болсон, олон улсын харилцаан дахь даяаршил, интеграцчилал идэвхжсэн зэрэг олон хүчин зүйлс эл бүс нутгийг цөмийн зэвсгээс ангид орчин болоход эергээр нөлөөлсөн.

Бангкокийн гэрээ буюу Зүүн Өмнөд Азийн цөмийн зэвсэггүй бүсүүд

1995 оны 12 сард АСЕАН-ы гишүүн орнууд Зүүн өмнөд Азийн Эдийн Засгийн Хамтын Ажиллагааны ээлжит чуулганаар энэ бүс нутгийг цөмийн

⁸ Resolution 1652, November 24, 1961 Mahmoud Karem “A Nuclear-Weapon-Free Zone in the Middle East Problems and Prospects”, NY, 1988, p 47

зэвсгээс ангид байлгах эрмэлзлийн доор цөмийн зэвсэггүй бүс үүсгэсэн тухай Бангкокийн гэрээг байгуулсан юм.⁹ Энэ нь ЗӨА-д Энх тайван, Төвийг сахисан бүс байгуулах тухай 1971 оны 11 сарын 27-ний Куала Лумпурын тунхаглалын хэрэгжилтийн хэсэг гэж үздэг.¹⁰

Өмнө нь байгуулагдаж байсан ЦЗБ-үүдийн нэгэн адил заалтууд Бангкокийн гэрээнд орсон байдаг ба эдгээрийг хянахад Олон улсын цөмийн эрчим хүчний агентлагтай нягт хамтран ажиллах талаар гэрээнд тодорхой заасан байдаг. Үүнд бусад бүсүүдээс нэг онцлог нь гэрээнд нэгдэгч орнуудын нутаг дэвсгэрээс гадна эх газрын хормойн ус (continental shelf), эдийн засгийн онцгой бүс (exclusive economic zone)-ийг хамруулсанд оршиж байдаг юм.¹¹

Төв Азийн цөмийн зэвсэггүй бүс буюу Самаркандын гэрээ

1991 онд ЗХУ задарснаар Төв Азид Казахстан¹², Узбекистан, Тажикстан, Туркменистан, Кыргызстан гэсэн таван улс тусгаар тогтнолоо зарласан билээ. Үүнээс Казахстан улс нь өөрийн нутаг дэвсгэр дээр байсан хуучин ЗХУ-ын цөмийн туршилтын Семипалатинскийн талбайг сайн дураар хааж, ЗХУ-ыг залгамжлагч нэг улсын хувьд цөмийн зэвсэгтэй байх боломжоос сайн дураар татгалзан, тусгаар тогтносон анхны жилүүдээсээ цэрэг зэвсэггүй, энх тайванч, цөмийн зэвсгийг хорогдуулах гадаад бодлогын чиглэлийг баримталж ирсэн.¹³

Төв Азид “хүйтэн дайн”-ы үед Зөвлөлтийн их хэмжээний цөмийн зэвсгийн нөөц¹⁴ байсан, ЗХУ-ын цөмийн туршилтын томоохон талбай энд байсан зэрэг нь бүс нутгийн улсуудын цөмийн зэвсгээс ангид байх эрмэлзлийг идэвхжүүлж, цөмийн зэвсэггүй бүс байгуулах санаачлага гаргахад нөлөөлсөн.

1997 оны 2 сарын 27-нд таван улсын төрийн тэргүүн нар Төв Азийн цөмийн зэвсэггүй бүс байгуулах Алма-Атын тунхаглал гаргаснаар эл бүс нутгийг цөмийн зэвсгээс ангид байлгах тухай бодит үйл явц эхлэхэд нөлөөлсөн¹⁵. Тунхаглалыг гаргасан таван улс нэгэн цагт Зөвлөлтийн цөмийн байгууламжийн хэсэгт хамрагдаж байсан нь Зөвлөлтийн цөмийн зэвсгийн үйлдвэрлэл, туршилттай холбогдох олон тооны аюултай үр дагавруудыг дагуулсаар ирснийг онцолсон байдаг. Зөвхөн цөмийн зэвсгээс ангид байснаар энэ төрлийн аюул заналаас үүдэлтэй эрсдэлийг багасгах боломжтой гэж үзсэн.

9 Хосбаяр, Дүгэрсүрэн. Олон улсын эрх зүй. УБ. 1998, 262-р тал

10 Ronald McCoy, IPPNW Co-President. THE SOUTHEAST ASIA NUCLEAR WEAPON-FREE ZONE TREATY

11 Treaty on the Southeast Asia NWFZ. Programme for Promoting Nuclear Non-Proliferation. Briefing Book. Vol. II. Treaties, Agreements and Other relevant Documents. (7th Ed.). F-23

12 40-өөд жилийн хугацаанд Семипалатинскийн талбайд ЗХУ 458 агаарын болон газар дорх цөмийн туршилт хийсэн ба үр дагавар нь 300 000 хавтгай дөрвөлжин км нутаг дэвсгэрийн 1 сая 700 мянган хүнд хортой нөлөөлсөн ба тэдгээрийн дунд явуулсан судалгаагаар ихэнх нь цацрагийн хордлого түүнээс үүдэн гарсан хорт хавдраар өвчилсөн байдаг. Herald Tribune, Asia Pacific

http://www.iht.com/articles/ap/2006/09/08/asia/AS_GEN_Central_Asia_Nuclear_Free_Zone.php

13 “Казахстан на пути ускоренной экономической, социальной и политической модернизации”: Послание Президента Республики Казахстан народу Казахстана. //Инф. материалы от Посольства Казахстана в Монголии. Сентябрь 2005г.

14 1991 онд ЗХУ задран унахад Казахстан 1410 цөмийн цэнэгт хошуутай үлдсэн. Үүнд “SS-18” Казахстан 1992 оны 7-р сарын 2-нд START I гэрээг соёрхон баталж 1994 оны 2-р сарын 14-нд Үл дэлгэрүүлэх гэрээнд нэгдэн орж, үүний дагуу 1995 оны 4-р сард үлдсэн цөмийн цэнэгт хошууг ОХУ-д шилжүүлж өгсөн байна.

1040 ширхэг SS-18 загварын нуужингийн цөмийн цэнэгт хошууг 1995 оны 42-р сарын 25-нд ОХУ руу тээвэрлэж, үлдсэн 104 ширхэг SS-18 загварын нуужинг 1996 оны 9-р сард устгахаар ОХУ руу мөн явуулсан. <http://www.nti.org/db/nisprofs/kazakst/weapons/nuclearw.htm>

15 “Text of Almaty Declaration on Aral Sea Pollution,” Народное слово (Tashkent), March 4, 1997, in FBIS Document FTS19970530002474.

Алма-Атын тунхаглал дээр үндэслэн 1997 онд НҮБ-ын ЕА-н чуулганаар дээрх таван улс “Төв Азид цөмийн зэвсэггүй бүс байгуулах” тухай тогтоол оруулсныг санал хураалгүй 52/35S тогтоол болгож баталсан байдаг.

1997 оны 9 сард таван улсын гадаад хэргийн сайд нар Ташкентад хамтарсан мэдэгдэл хийж, Төв Азид цөмийн зэвсэггүй бүс байгуулах ажилд НҮБ-тай нягт хамтран ажиллахаар тохиролцсон. Уг ажлын үр дүнд 2002 оны 9 сарын 27-нд Төв Азид цөмийн зэвсэггүй бүс байгуулах Самаркандын гэрээг байгуулж, 2006 онд гарын үсэг зурсан.

Монгол улсын “Нэг улс цөмийн зэвсэггүй статус”

1990 оноос өмнө манай улсад ЗХУ-ын цэрэг байрлаж Монгол улсын тусгаар тогтнолыг хамгаалах баталгаа болж байв. 1992 онд Зөвлөлтийн сүүлчийн цэрэг Монголоос гарч мөн оны 9-р сарын 25-нд болсон НҮБ-ын Ерөнхий Ассамблейн (ЕА) 45-р чуулган дээр Ерөнхийлөгч П.Очирбат үг хэлж, Монгол Улс цөмийн зэвсэггүй бүс болсныг зарласан. Монгол улсын энэхүү алхам нь 1968 оны Цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх гэрээ, 1974 оны 12-р сарын 9-нд НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас баталсан 3261 F тогтоолын дагуу нэг улс дангаараа цөмийн зэвсэггүй бүс болох алхам болсон. Уг тогтоолд “ЦЗБ байгуулахтай холбогдсон үүрэг бүлэг улсууд, түүн дотроо газар зүйн том бүс нутгууд, нэг тивийг төдийгүй цөөн тооны улсууд, тэр ч бүү хэл нэг улсыг ч хамарч болно”¹⁶ гэсэн заалтын дагуу 1998 онд НҮБ-ын ЕА-аас A/RES/53/77/D “Монгол улсын олон улсын аюулгүй байдал, цөмийн зэвсэггүй бүсийн статус” хэмээх нэг улсын цөмийн зэвсэггүй статусыг дэмжих тухай тогтоол гаргасан нь Монголын талын идэвхтэй үйл ажиллагааны үр дүн юм. НҮБ-ын ЕА Монголын бодлого, санаачилгыг дэмжин хүлээн авч гишүүн бүх улс орнуудыг ЦЗБ байгуулах, түүний аюулгүй байдлыг бэхжүүлэхэд хамтран ажиллахыг уриалсан. Ингэснээр НҮБ-ын ЕА “тус бүс нутаг дахь энхийн, нөхөрсөг, харилцан ашигтай харилцааг хөгжүүлэхэд оруулж буй Монголын идэвхтэй, эерэг оролцоог” дэмжиж байгаагаа илэрхийлж, энэ нь аюулгүй, тогтвортой байдлыг бэхжүүлэхэд өндөр хувь нэмэртэй болохыг илэрхийлсэн.

2000 оны 2 дугаар сарын 3-нд Цөмийн зэвсгээс ангид байх тухай Монгол улсын хууль, түүнтэй холбогдуулан авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай УИХ-ын 19 тоот тогтоолыг баталж өөрийн статусаа үндэсний хэмжээнд тодорхойлсон. Уг хууль нь Монгол улсын цөмийн зэвсэггүй статустай холбогдуулан цөмийн зэвсгийг боловсруулах, үйлдвэрлэх, бусад аргаар олж авах, эзэмших, хяналтандаа байлгах, байрлуулах, аливаа хэрэгслээр тээвэрлэх, туршилт хийх, цөмийн зэвсгийн гаралтай тусгай ангиллын цацраг идэвхт материал, шаар болон аюултай хог хаягдлыг булшлах, устгахыг хориглосон¹⁷.

2000 онд Монгол улсын цөмийн зэвсгээс ангид хуультай танилцсаны дагуу Ерөнхий Ассамблейн 55 дахь чуулганаас A/55/56-S/2000/16 баримт бичгийг гаргав.¹⁸ Энэ нь НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн (АЗ) байнгын таван

¹⁶ Enkhsaihan, J. *Developing nuclear landscape in the Asian heartland: risks and prospects.* “Олон улсын харилцаа”. 2003. №1., УБ. 145 дугаар тал

¹⁷ Цөмийн зэвсгээс ангид байх тухай Монгол улсын хууль. УБ. 2000

¹⁸ <http://www.opanal.org/NWFZ/Mongolia>

гишүүн Монгол улсын геополитикийн онцлог байдлыг харгалзан үзэж цөмийн зэвсэггүй бүсийн статусыг тусгайлан авч үзэхээр болов¹⁹.

2000 оны 10 сард НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 55-р чуулганаар Аюулгүйн Зөвлөлийн таван гишүүн улс А/55/530-S/2000/1052 баримт бичиг болох “Монголын цөмийн зэвсэггүй бүсийн статус, олон улсын аюулгүй байдал”²⁰ хэмээх хамтарсан мэдэгдэл гаргаж, Монголын цөмийн зэвсэггүй бүсийн статусын талаарх 53/77D тогтоолыг хэрэгжүүлэхэд Монгол улстай хамтран ажиллахаа баталсан юм.

2000 оны 11-р сард НҮБ-ын ЕА 53/77 D тогтоолыг үндэслэн 55/33S тогтоолдоо Монголын цөмийн зэвсэггүй бүсийн статусын талаар баталсан Монгол улсын хуулийн дагуу гишүүн бүх орнуудыг Монголын цөмийн зэвсэггүй бүсийн статус, түүний олон улсын аюулгүй байдлыг бэхжүүлэх арга хэмжээ авахад хамтран ажиллахыг урьсан байдаг²¹. Монголын талын хүсэлтийг харгалзан үзэж НҮБ-ын ЕА-н 55/33S тогтоолын дагуу НҮБ-ын бие даасан мэргэжилтнүүдийн бүлгийн дэмжлэгтэйгээр Ази-Номхон далайн бүсийн төвөөс 2001 оны 9 дүгээр сарын 5-6-нд Саппоро хотноо хурал зохион байгуулав. Уг хуралд цөмийн зэвсэгтэй таван гүрэн, Монгол болон НҮБ-ын шинжээчид оролцож, манай улсын цөмийн зэвсэггүй статусыг цаашид олон улсын хэмжээнд баталгаажуулах асуудлыг хэлэлцэж зөвлөмж гаргасан. Уг зөвлөмжөөр Монгол улс хоёр хөрштэйгөө гурван талт гэрээ байгуулсны үндсэн дээр бусад гүрнүүд хүлээн зөвшөөрөх асуудлыг тавьсан байна. Энэ хүрээнд Монгол улс хоёр хөрш улсдаа гэрээний төслийг өргөн бариад байгаа билээ.

Дэлхийн цөмөөс ангид байх болон цөмийн зэвсэггүй бүсүүдийн зэрэгцээ Ойрхи Дорнод, Хойд Африкийн бүс нутаг болон Өмнөд Азийн цөмийн зэвсэггүй бүсийн асуудал тавигдаж байгаа билээ. Эдгээр бүс нутаг нь нэлээд зөрчилдөөний шинжтэй байдаг учраас цөмийн зэвсэг эзэмших асуудал энэ бүс нутагт хурцаар тавигдаж байгаа юм.

Энэтхэг бүр 1946 оноос Хятадтай хил орчмын зөрчилтэй байдал болон түүнээс үүдсэн маргааныг шийдвэрлэж, аюулгүй байдлаа хангах зорилгоор цөмийн зэвсэг эзэмших асуудал ярьж эхэлсэн ба Энэтхэгийн цөмийн хөтөлбөр нь түүний хөрш Пакистан улсыг мөн аюулгүй байдлаа хамгаалах үүднээс цөмийн зэвсэглэлээр хөөцөлдөхөд хүргэсэн. Өнөөг хүртэл энэ хоёр орны нэг нь цөмийн зэвсэг туршихад маргааш нь нөгөө улс нь мөн турших жишээтэй байна.

Хойд Африк, Ойрхи Дорнодын бүс нутагт цөмийн зэвсэггүй бүс байгуулах асуудал яригдаж байгаа боловч хоёр иргэншлийн хоорондын болон геополитикийн хүчин зүйлийн улмаас маргаан зөрчилтэй байгаа энэ бүс нутагт төдийлөн хэрэгжиж чадахгүй байна. Хэдийгээр Египет бүр Насерын үед цөмийн зэвсэггүй бүсийн асуудал тавьж байсан боловч тус бүс нутгийн нөлөө бүхий орон болох Израйль барууны орнууд, тухайлбал АНУ, Францын дэмжлэгтэйгээр цөмийн хөтөлбөр хэрэгжүүлж өнөөдөр цөмийн зэвсэгтэй гэдгээ албан ёсоор зарлаагүй ч гэсэн эзэмшиж байдаг нь тус бүс нутгийн аюулгүй байдалд итгэлцлийн механизмыг буй болгоход хүндээр тусаж байгаа юм.

Дэлхийн олон орон, бүс нутаг цөмийн зэвсэггүй бүс нутаг болох асуудлыг аюулгүй байдлаа хангах гол хүчин зүйлийн нэг гэж үзэж байгаа ба цаашид ч энэ үйл явц улам өргөжих хандлагатай байгаа юм.

¹⁹ <http://disarmament.un.org/rcpd/mongolia.htm>

²⁰ Мөн тэнд

²¹ Мөн тэнд